

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ,
АРГА ХЭМЖЭЭ

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/ | 2022 онд хүрэх түвшин |
|---|--|---|--|
| 1 | 2 | 3 | 4 |
| Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд | | | |
| 1 | Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хийж, төрийн үйлчилгээг сайжруулах | Тоо: Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн Чанар: Судалгааны дүнд үндэслэн доголдлыг сайжруулахаар зохион байгуулсан арга хэмжээ Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнасан байна. | Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээр сахилга хариуцлагыг сайжруулж төрийн үйлчилгээг шуурхай болгосон байна. |
| 2 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах | Тоо: Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналтад авсан заалтын тоо Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтын тоо Чанар: Орон нутагт хэрэгжүүлсэн ажлын үр дүн Хугацаа: Журмын хугацаанд | Засгийн газрын бодлого шийдвэрийг сум орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлсэн байна |
| 3 | Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцож тайлагнах | Тоо: Аймгийн таван жилийн үндсэн чиглэлийн хяналтад авсан заалтын тоо Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналтад авсан заалтын тоо 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хяналтад авсан заалтын тоо Чанар: Орон нутагт хэрэгжүүлсэн үр дүн Хугацаа: Журмын хугацаанд | Орон нутаг хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний үр дүн |
| 4 | Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, тайлагнах | Тоо: Аймгийн ИТХ-ын тогтоолын хяналтад авсан заалтын тоо Захирамжийн хяналтад авсан заалтын тоо Албан даалгаврын хяналтад авсан заалтын тоо Чанар: Сумдын Засаг дарга нарт даалган гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь Хугацаа: Журмын хугацаанд | Орон нутаг хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний үр дүн |
| 5 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, | Тоо: Сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах | Албан хаагчдын ажиллах нөхцөл, сурч хөгжих боломж бүрдэж, хөтөлбөр |

| | | | |
|---|--|--|--|
| | төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Чанар: Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, суралцах боломжийг бүрдүүлсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жил | төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдсан байна |
| 6 | Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бүх шатны байгууллага, ажиллагсадтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллах | Тоо: Иргэдээс төрийн байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийн талаар сэтгэл ханамжийн судалгааг 2-оос доошгүй удаа авсан байна Хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцсон эсэх Чанар: Судалгаа мөрөөр хийсэн ажил арга хэмжээ, гарсан үр дүн Албан хаагчдын үүрэг хариуцлага, алдаа дутагдал арилсан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна. Албан хаагчдын үүрэг хариуцлага сайжирсан байдал |
| 7 | Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулан ажиллах | Тоо: Албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах 1-2 онцлог арга хэмжээ зохион байгуулах Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчийн тоо Гэмт хэрэгт холбогдсон албан хаагчийн тоо Чанар: Сахилга хариуцлага, ёс зүйн зөрчилгүй хамт олон болсон байна Хугацаа Журмын хугацаагаар | Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн ажилласан байна. |
| 8 | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг сумын хэмжээнд зохион байгуулж, төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулалтгүйгээр томилохгүй байх | Тоо: Зөрчилтэй томилгоо хийхгүй байх Чанар:Төрийн албаны стандартын хэрэгжилт, үр дүнг сайжруулсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. |
| 9 | Сумын төрийн байгууллагуудын дотоод, гадаад үйл ажиллагааг хяналт, удирдлагын нэгдсэн "ERP" системээр явуулж, мэргэжилтэн ажилтан бүр ашиглалтыг сайжруулах, удирдлага хяналт тавих | Чанар: Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн бүх модулиудын ашиглалтыг 100 хувьд хүргэх, Төсвөөс цалин авч байгаа бүх албан хаагчийг албаны и-мэйл хаяг үүсгэн "захидлын програм" болон цалингийн нэгдсэн системд холбож албан харилцаанд ашиглаж хэвшүүлэх | Байгууллагын дотоод үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, <ul style="list-style-type: none"> • Удирдлагын хяналт, • Хүний нөөцийн мэдээлэл, • Ажил төлөвлөлт, • Үүрэг даалгавар, • Хурал, • Ажлын хэсэг, |

| | | | |
|----|--|---|--|
| | | Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | <ul style="list-style-type: none"> • Өргөдөл гомдол, • Албан бичиг, харилцаа, • Цаг бүртгэл, • Тайлан, • Судалгаа “ERP” систем ашиглан өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж хэвшсэн байна. |
| 10 | Сумдын албан ёсны цахим хуудасны ашиглалтыг нэмэгдүүлж, өдөр тутмын мэдээ мэдээллийг нийтэлж сумын “Ил тод байдал”-ын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллах | Тоо: Үндсэн мэдээллийн агуулга, үйл ажиллагаа, Төсөв санхүү, Хүний нөөц, худалдан авах ажиллагаа зэрэг 4 төрлөөр байршуулсан мэдээ мэдээллийн тоо, хандалтын тоо Чанар: Төрийн байгууллагуудын ил тод байдлын шалгуур үзүүлэлт хангагдаж төрийн үйлчилгээ иргэдэд хүрсэн байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Иргэдийг цахим орчинд мэдээ мэдээллээр хангаж, сумын ил тод байдлыг нэмэгдүүлсэн байна |
| 11 | Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжил, нийгэм эдийн засгийн байдлын талаар иргэд олон нийтэд сурталчлах, ил тод нээлттэй, мэдээлэх, “Өнөөгийн Баянхонгор” сониныг захиалах | Тоо:Сумын албан ёсны цахим хуудасны бүх цэсэд байршуулсан мэдээллийн тоо, чанар хүртээмж “Өнөөгийн Баянхонгор” сониныг захиалсан иргэдийн тоо Чанар:Цахим хуудасны бүс цэсэнд мэдээллээ тогтмол (шуурхай) байршуулж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | Баянхонгор аймгийн албан ёсны цахим сайтад бүх сумдын мэдээллийн сан бүрдэж, төрийн үйл ажиллагааны нэгдсэн тоо баримт бүхий бодит мэдээ мэдээллийг нэг цонхоор хүргэсэн байна. |
| 12 | Сумын цахим мэдээллийн самбар буюу Dashboard-нд өдөр сар улирал, хагас жилээр гардаг тоон мэдээллийг үнэн зөв оруулж хэвших | Тоо: 192 үзүүлэлтээр оруулсан тоон мэдээллийн тоо, чанар хүртээмж Чанар: 192 төрлийн тоон мэдээллийг хариуцсан ажилтан, мэргэжилтнээр цаг тухай бүрд оруулсан байдал Хугацаа: Улирал бүр тайлагнана. | Иргэд, ААН сумын хэмжээний тоон мэдээлэл, өдөр тутмын үйл ажиллагааны талаар цахимаар мэдээлэл авах боломж бүрдсэн байна. |
| 13 | Тоон гарын үсэг ашиглаж цаасны хэрэглээг багасгах | Тоо: ERP системийн 3-с доошгүй модулийг ашиглан тоон гарын үсгээр баталгаажуулж хэвших Чанар: Сумын хэмжээнд шийдвэр гаргах түвшний удирдлагын тоон гарын үсэгтэй болсон байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | Цаасгүй технологийг нэмэгдүүлж, байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системд тоон гарын үсэг ашиглаж хэвшсэн байна. |

| | | | |
|--|---|--|---|
| 14 | Байгууллагуудын интернет сүлжээний хурдыг нэмэгдүүлж, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах, мэргэжилтэн ажилтнуудын мэдлэгийг сайжруулах | Тоо: Мэдээллийн технологийн сургалтад хамруулсан ажилтан, мэргэжилтнүүдийн тоогоор Чанар: Байгууллагуудын интернетийн урсгалын хурдыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг сайжруулснаар Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | Цахим шилжилт, цахим засаглалын хүрээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд техникийн болон хүний нөөцийн мэдлэг, ажиллах нөхцөл сайжирсан байна. |
| 15 | Гадаад бодлогыг хэрэгжүүлэхдээ харьяалах нутгийн захиргааны байгууллагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу чанартай зохион байгуулах | Тоо: Гадаад арга хэмжээний тоо -Хамтран ажиллах удирдамж хөтөлбөрийг батлуулсан эсэх Санамж бичиг гэрээ хэлэлцээрийн тоо Хамтран ажиллах гэрээг хянуулж, зөвшөөрөл авсан эсэх Чанар: Гадаад арга хэмжээг чанартай үр дүнтэй зохион байгуулах Хугацаа: Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ажлын 7 хоногт багтаан тухай бүр танилцуулж тайлагнана | Сум орон нутагт гадаад бодлого хамтын ажиллагаа үр дүнтэй зохион байгуулагдсан байна |
| 16 | Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг сум орон нутагт амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэх | Тоо: Тухай суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн тоо Чанар: Төсөл хөтөлбөрийг хариуцлагатай, хамтын уялдаа холбоотой үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх Хугацаа: Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хагас бүтэн жилээр тайлагнана | Төсөл хөтөлбөрийн үр өгөөж нэмэгдсэн байна. |
| Гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд | | | |
| 17 | Аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр сум орон нутагт шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах | Тоо: Зохион байгуулсан ажил арга хэмжээ Чанар: Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж ажиллах Хугацаа: Хэрэгжилтийг 6 сар, 11 сард үнэлж тайлагнасан байна | Сум орон нутагт цаг үеийн арга хэмжээг хурдан шуурхай үр дүнтэй зохион байгуулсан байна. |
| 18 | Сумын Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагааг 24 цагийн горимоор ажиллуулж үйл ажиллагааг эрчимжүүлэх албан тушаалтнуудыг үүрэгжүүлэх | Тоо: 180 удаа Чанар: Шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлсэн байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Шуурхай штабын бэлэн байдал хангагдсан байна |
| 19 | Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хагас бүтэн жилээр тодотгол хийж, хэрэгжилтийг хангах | Тоо: 2 удаа Чанар: Гамшгаас хамгаалах мэдээлэл шинэчлэгдсэн байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний мэдээлэл шинэчлэгдсэн байна |

| | | | |
|--|--|--|---|
| 20 | Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцасны нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлэх | Тоо: Тухай бүр Чанар: Хамгаалах хэрэгслийн нөөцийг 20 хувиар нэмэгдүүлсэн байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Хамгаалах хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна |
| 21 | Гамшгаас эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар Сумын Засаг даргын нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлэх | Тоо: Тухай бүр Чанар: Нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлсэн байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Гамшгийн нөөц хөрөнгийг бүрдүүлсэн байна |
| 22 | Мал амьтны шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгаалах, хорио цээрээр хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажиллах, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | Тоо: Тухай бүр Хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажиллах Соён гэгээрүүлэх ажлыг 4 удаа зохион байгуулах Чанар: Хорио цээрээр хязгаарлалтыг тогтоох, Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажилласан байна. Иргэд малчдын, хүн мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилсэн байна |
| 23 | Сумын сайн дурын бүлгийг томилгоожуулж үйл ажиллагааг жигдрүүлэх | Тоо: 1-2 бүлгэмийг байгуулах Чанар: Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох бүлгүүдийн идэвх оролцоо нэмэгдсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Сум тус бүр гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг байгуулагдаж гамшиг ослын үед үүрэг гүйцэтгэх хүн хүч нэмэгдсэн байна |
| 24 | Гамшиг осол, аюулт үзэгдэл гал түймэр, хүн мал амьтны гоц халдварт өвчний үед ажиллах гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах | Тоо: Тухай бүр Чанар: Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн үүрэг оролцоог сайжруулсан байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Сумын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангасан байна |
| Хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд: | | | |
| 25 | “Зөв амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, архины хамаарал бүхий иргэдийг эмчилгээнд хамруулж, ажлын байраар хангах | Архинаас татгалзсан иргэдийн тоо Эмчилгээнд хамрагдаж, хөдөлмөр эрхлэсэн иргэдийн тоо Шалтгаант гэмт хэрэг буурсан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | 10 иргэн татгалзаж, 5 иргэн тогтмол хөдөлмөр эрхлэсэн байна Шалтгаант гэмт хэрэг өмнөх оноос нэг нэгжээр буурсан байна |
| 26 | Цагдаагийн хэсгийн төлөөлөгтэй гэрээ байгуулж гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | Тоо: Гэмт хэрэг, зөрчлийн тоо Чанар: Гэмт хэрэг зөрчлийн тоог өмнөх оноос 0.5 хувиар буурсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр | Гэрээ байгуулж хагас бүтэн жилээр дүгнэсэн байна Сумын хэмжээнд гэмт хэргийн тоо буурсан байна |
| 27 | Авлигын эсрэг, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцох | Тоо: Хамрагдсан иргэдийн тоо Чанар: Гарсан үр дүн Хугацаа: Хагас бүтэн жилээр | Иргэд, төрийн албан хаагчдын мэдлэг дээшилсэн байна. |
| 28 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг | Тоо: 10-аас доошгүй арга хэмжээ Чанар: Хөтөлбөрийг | Иргэдийн эрх зүйн боловсрол дээшилсэн байна. |

| | | | |
|--|--|--|---|
| | хэрэгжүүлж, үр дүнг тооцох | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 100% Хугацаа:Жилдээ | |
| 29 | “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” аймгийн дэд хөтөлбөрийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, Орон нутгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой бодитой ажлыг зохион байгуулах | Тоо:Тус бүр 5-аас доошгүй арга хэмжээ Чанар: Төлөвлөгөөний биелэлт 100% Хугацаа: Жилдээ | Гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байна. |
| 30 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, баримтын бүрдүүлэлт, шийдвэрлэлтийг шинэ шатанд гаргах | Тоо: Тухай бүр Чанар: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 100% Хугацаа:Жилдээ | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. |
| 31 | Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийт ажилтнууд 16 цагийн сургалтад хамрагдах | Тоо: Төрийн албан хаагчдын тоогоор Чанар: Төрийн албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байна. Хугацаа:Жилдээ | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар дээшилсэн байна. |
| 32 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын үндсэн санд 2019 оны байнга хадгалах болон 2020 оны мал тооллогын баримтыг тус тус цаасаар болон цахим хувь, дансны хамт шилжүүлэх | Тоо: Сумын 6 байгууллага баримтаа бүрэн шилжүүлснээр Чанар: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 100% Хугацаа:Тусгай графикаар | Байгууллагын баримтыг бүрэн шилжүүлсэн байна. |
| 33 | “Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах | Тоо: Тухай бүр Чанар: байгууллага бүр архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна. Хугацаа:Жилдээ | Байгууллага бүр архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан байна. |
| 34 | Байгууллагын тусгай төрлийн /гэрэл зураг, дуу дүрсний/ 2021 оны баримтыг Төрийн архивт шилжүүлэх | Тоо: Төрийн 6 байгууллага тусгай төрлийн баримтыг бүрэн шилжүүлснээр Чанар: 100 хувь хүлээлгэн өгсөн байна. Хугацаа:Жилдээ | Баримтыг архивт шилжүүлсэн байна. |
| Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг сайжруулах хүрээнд: | | | |

| | | | |
|----|---|---|--|
| 35 | Орон нутагт боловсролын тулгамдаж буй асуудлыг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн, гарсан санал санаачлагыг бүрэн хэрэгжүүлэх | Тоо: 2-оос доошгүй удаа хэлэлцүүлэх Чанар: Боловсролын үйлчилгээний чанарт ахиц гарсан байна Хугацаа: Нийгмийн бодлогын хэлтэст хагас бүтэн жилээр тайлагнасан байна. | Тулгамдсан асуудал шийдвэрлэсэн байна. |
| 36 | Таван настнуудыг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах, малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих | Тоо: 5 настай хүүхдийн тоо Чанар: Сургуулийн өмнөх боловсролыг бүрэн эзэмшүүлж, сургуульд бэлтгэгдсэн байна. Хугацаа: 2022 оны 09-р сард | Таван настнуудыг бүрэн хамруулж, сургуулийн өмнөх боловсрол олгож, сургуульд бэлтгэсэн байна |
| 37 | Сургуулийн дотуур байрны орчны эрсдэлийн үнэлгээг хийж, хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай | Тоо: 3 стандартыг хангана Чанар: MNS6782:2019, MNS6558:2015, MNS 6781 :2019 стандартын шаардлагад нийцүүлсэн байна. Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна Хугацаа: Хагас бүтэн жилээр | Хүүхэд хамгааллыг сайжруулсан байна. |
| 38 | Хэлний бодлогын сумын салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, төрийн албан хаагчдын болон иргэдийн “Монгол бичиг”-ийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх | Тоо:Төрийн албан хаагчдын тоо Иргэдийн тоо Чанар: Төрийн албан хаагчдын 90 –дээш хувийг “Монгол бичиг”-ийн анхан, дунд, ахисан түвшиний сургалтад хамруулсан байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр | Төрийн албан хаагчдын монгол бичгийн ур чадвар дээшилж, төрийн албыг монгол бичгээр хослон эрхлэх бэлтгэлийг хангасан байна |
| 39 | Цэцэрлэг, сургуулийн сурагчдын эрүүл ахуйн стандартыг хангуулах, сургууль, цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, багш ажилтнууд болон сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг сайжруулах, саван ариутгалын бодисын хангамжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих | Тоо: Стандартын дагуу ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийсэн байна Иргэд, аж ахуй нэгжийн хандив тусламжийн хэмжээ Чанар: Орчны ариун цэвэр халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу хийсэн байна Ариутгалын бодисын хангамжийг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлэх Хугацаа: Хагас бүтэн жилээр | Сургууль цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт сайжирч халдвар өвчний гаралт буурсан байна. Иргэд, аж ахуй нэгжээс ирсэн хандивын хэмжээ Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, багаж хэрэгслийн хангамж нэмэгдсэн байна |
| 40 | Багш, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах | Тоо: Багш, ажилтан, суралцагчдын 80-аас доошгүй хувийг хамруулсан байна. Нийгмийн баталгааг хангахад зарцуулсан төсвийн хэмжээ /тусламж/ Чанар: Багш, удирдах ажилтныг тогтвор | Багш нарын нийгмийн баталгааг хангахад ахиц гарсан байна. |

| | | | |
|---|---|--|--|
| | | суурьшилтай ажиллуулсан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр | |
| 41 | Багш, нарын мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, “Багш хөгжлийн төв”-д дэмжлэг үзүүлэх; | Тоо: Чадваржуулсан багш, удирдах ажилтны тоо Чанар: Багш ажилтны мэдээлэл холбооны технологи ашиглах ур чадвар дээшилсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр | “Багш хөгжлийн төв” –ийн үйл ажиллагаа өргөжиж багш удирдах ажилтны ажлын байран дээрх мэргэжил, ур чадвар сайжирсан байна |
| 42 | Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах | Тоо: 2-11 дүгээр ангийн сурагчдын тоо Чанар: Хоцрогдлыг 15–аас дээш хувиар бууруулсан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр | Хүүхдийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бага суурь боловсролын стандартыг хангасан байна. |
| 43 | Сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх, тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, тохирлын баталгаанд хамруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах | Тоо: Эрхэлж буй туслах аж ахуйн тоо Чанар:Төмс хүнсний ногоо тарих, мал, тахиа, гахайн аж ахуй эрхлэх, -Сум орон нутагт үйл хоол хүнсний чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгжтэй хамтран ажиллах Хугацаа: Хагас бүтэн жилээр | Сургуулийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ахиц гарч, хүнсний аюулгүй байдал хангагдсан байна. |
| 44 | Иргэдэд нөхөн боловсрол олгож, ерөнхий түвшнийг дээшлүүлж, өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх | Тоо: Нөхөн боловсрол олгох сургалтад хамрагдах иргэдийн тоо Насан туршийн боловсролын сургалтад хамрагдсан иргэдийн тоо Өрхийн хөгжлийн судалгаанд хамрагдсан өрхийн тоо Чанар: Иргэдийн боловсролын чанар дээшилсэн байна Хугацаа: Хагас бүтэн жилээр | Иргэдийн амьдрах чадвар нэмэгдсэн байна |
| Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: | | | |
| 45 | Иргэн бүрийг хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх | Тоо: Хамрагдсан иргэд Чанар: Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь Хугацаа: Бүтэн жилээр | Хүн амын 80-аас дээш хувийг хамруулсан байна |
| 46 | Сургууль цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар хүртээмжийг сайжруулан (“үдийн хоол”, “эрүүл шүд”) хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангах | Тоо: Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан хүүхдийн тоо Чанар: Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалсан байна Хугацаа: Бүтэн жил | Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалсан байна |
| 47 | Эх, нялхас, 5 хүртэлх насны | | Өмнөх оноос 0.5 хувиар |

| | | | |
|---|---|--|---|
| | хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулах | Чанар: Эндэгдлийг бууруулсан хувь Хугацаа: Хагас бүтэн жилээр | буурсан байна. |
| 48 | Алслагдсан багийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г сумандаа зохион байгуулах | Тоо: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо Чанар: Алслагдсан багийн хүн амын эрүүл мэндийн эрсдлийг бууруулсан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр | “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г алслагдсан багуудад хүргэж, эрүүл мэндийн чанарын үзүүлэлтийг сайжруулсан байна. |
| 49 | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Тоо: Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо Хувь: Хамралтын хувь | Эрүүл мэндийн даатгалын хамралтыг өмнөх оноос нэмэгдүүлсэн байна. |
| Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд: | | | |
| 50 | Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | Байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | Байнгын ажлын байраар 15-20, түр ажлын байраар 100-150 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ |
| 51 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэн нийгмийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх | Ээлтэй орчин бүрдүүлсэн аж ахуй нэгж байгууллагын эзлэх хувь Хугацаа: Хагас бүтэн жилээр | Үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж байгууллагын 50-иас дээш хувь нь хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байна |
| 52 | Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллах | Байгуулсан хэлэлцээрийн тоо, биелэлтийн хувь Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана | Төрийн байгууллагуудад бүрэн хэрэгжүүлнэ |
| 53 | Ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх | Арга хэмжээний тоо, оролцогсдын хувь Хугацаа : Хагас бүтэн жилээр | 5-аас дээш арга хэмжээ зохион байгуулж нийт ахмадын 60-аас дээш хувийг оролцуулсан байна |
| 54 | Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд малчдыг хамруулах | Сайн дурын даатгалд хамруулсан малчдын хувь Хугацаа: Хагас бүтэн жилээр | Нийт малчдын 60-аас дээш хувийг сайн дурын даатгалд хамруулсан байна. |
| 55 | Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулах | Гишүүдийг чадавхжуулсан арга хэмжээний тоо, төлөвлөгөөний биелэлтийн хувь, кейс илрүүлэлт, шийдвэрлэлтийн хувь, батлагдсан төсөв Хугацаа : Хагас бүтэн жилээр | Чадавхжуулах арга хэмжээ 2-оос дээш, төлөвлөгөөний биелэлтийг 80-аас дээш, кейс илрүүлэлт, шийдвэрлэлтийн хувийг 70-аас дээш хувьтай хэрэгжүүлж, үйл ажиллагааны төсөд нэмэгдсэн байна. |
| 56 | Жендэрийн дэд салбар хороог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах | Дэд салбар хорооны төлөвлөгөөний биелэлт | Дэд салбар хороодын гишүүдийн чадавх нэмэгдэж төлөвлөгөө 80-аас дээш хувьтай биелсэн байна. |
| Соёл, спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд | | | |
| 57 | Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, | Тоо: Зохион байгуулсан арга хэмжээ, үйлчлүүлсэн | Соёлын төвийн орчин нөхцөл сайжирч, үйлчлүүлэгч |

| | | | |
|---|--|---|--|
| | иргэдийг соён гэгээрүүлэх | иргэдийн тоо Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээний тоо Чанар: Орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулсан байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр | иргэдийн тоо нэмэгдсэн байна. |
| 58 | “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх | Тоо: Нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгчдийн тоо, Чанар: Иргэдийн мэдлэг, хандлага өөрчлөгдсөн байна. Хугацаа: Жилдээ | Дасгал хөдөлгөөнөөр хичээллэгчдийн тоо нэмэгдсэн байна. |
| 59 | Угийн бичгийг хөтлөх, хэрэглээг нэмэгдүүлэх | Тоо: Нийт өрхийн хэрэглээний хувь | Нийт өрхийн 20-оос дээш хувь нь хөтлөж хэвшсэн байна |
| Төсөв, төрийн сангийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хүрээнд: | | | |
| 60 | Улсын болон орон нутгийн 2022 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг хугацаа алдалгүй тендер зарлаж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, | Тоо: Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын тоо Чанар: Аймгийн вэб сайтад, зарлагдсан тендер, сонгон шалгаруулалтын үр дүнг тухай бүрд байршуулж мэдээлсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээ, мэдээллийг цахим системд оруулж бүртгэлжүүлэн тогтмол хяналттай болгосон байна. Хугацаа: Тухайн бүрд хяналт тавьж цахимд байршуулсан байна. | Хуулийн дагуу худалдан авалт хийсэн байна Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна |
| 61 | Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу нийтэд ил тод болгох мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд багтаан үнэн зөв мэдээлэх | Тоо: 12 удаа Чанар: Төсвийн мэдээллийн ил тод байдал хангагдана. Вэб сайтад байршуулж, мэдээлэгдсэн байна Хугацаа: Сар бүр зөв мэдээлсэн байна | Төсвийн ил тод байдал хангагдсан байна |
| 62 | Сум хөгжүүлэх сангийн 2011 оноос хойш хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг барагдуулах | Тоо: Хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлт 100 хувьтай байна. Чанар: Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байна Хугацаа: Сар бүр үр дүнг тооцсон байна. | Сум хөгжүүлэх сан алдагдалгүй болсон байна |
| 63 | Олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг батлагдсан хуваарь зориулалтын дагуу зарцуулах | Тоо: Олгосон санхүүжилт, шилжүүлэг Чанар: Өр, авлага үүсгээгүй байна. ОНХС-гаас зарцуулахыг хориглосон ажлыг санхүүжүүлэхгүй байна. Хугацаа: Сар бүр тайлагнасан байна. | Төсвийн сахилга бат сайжирсан байна |

| | | | |
|----|---|--|---|
| 64 | Улс, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлж, төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх | Тоо: Өгөгдсөн орлогын төлөвлөгөө Чанар: Төлөвлөгөөг биелүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлэх Хугацаа: Хагас бүтэн жилээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байна. | Төсвийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна |
| 65 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 18/14 дүгээр “Бичил худалдаа, ажил үйлчилгээний албан татварын хэмжээ” тогтоолын хэрэгжилтийг хангаж хувиараа хүн тээвэр, ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгч лангуу болон ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс албан татварыг төсөвт төвлөрүүлэх, | Тоо: Өгөгдсөн орлогын төлөвлөгөө Чанар: Тогтоолын хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллах Хугацаа: Хагас бүтэн жилээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байна. | ХХОАТ-ын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна |
| 66 | Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн бодит үнэлгээгээр шинэчлэн тогтоож, орлогыг нэмэгдүүлэх | Тоо: Өгөгдсөн орлогын төлөвлөгөө Чанар: Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн бодит үнэлгээгээр шинэчлэн тогтоосон байх Хугацаа: Хагас бүтэн жилээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байна. | Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн бодит үнэлгээгээр шинэчлэн тогтоож дагаж мөрдсөн байна |
| 67 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, суманд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, төлбөрийн баримтын олгож хэвших | Тоо: Төлбөрийн баримт олгож буй хувь хүн аж ахуйн нэгжийн хувиар Чанар: Үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбуулж, төлбөрийн баримтын тухай бүр олгуулж хэвших. Хугацаа: Хагас бүтэн жил | Үйл ажиллагаа эрхлэгчдийг цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, төлбөрийн баримтын тогтмол олгодог болсон байна. |
| 68 | Аймгийн Засаг дарга, газрын албанаас олгосон газар эзэмших, ашиглах эрх, тэдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж орлогыг нэмэгдүүлэх | Тоо: Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтээр Чанар: Ногдуулалтыг 100% хийсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнасан байна. | Цахимжуулалтыг бүрэн хийж, орлогын төлөвлөгөөг давуулсан биелүүлсэн байна |
| 69 | Тухайн сумд бүртгэлтэй ААН, байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд e-balance.mof.gov.mn цахим хуудсаар тайлагнасан байх | Тоо: Бүртгэлтэй ААН -н тоо Чанар: Хуулийн хугацаанд тайланг үнэн зөв шивсэн байх Хугацаа: Жил бүрийн дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор | Тайлангийн ирц 85 хувьд хүрч, өмнөх оноос 10 хувь нэмэгдсэн байна |

| | | | |
|--|---|---|--|
| 70 | Байгууллагуудын үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулах | Тоо: Байгууллагын эрсдэлийг 1 улиралд үнэлэх, дотоод хяналтыг 2 удаа хийх Чанар: Эрсдэлийн түвшин буурсан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлан | Байгууллагын эрсдэлийн түвшинг бууруулсан байна |
| 71 | Хяналт шалгалт, дотоод аудитаар өгсөн зөвлөмж түүний хэрэгжилтийг хангах | Чанар: Зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэх Хугацаа: Хугацаанд тайлагнах | Зөрчил бүрэн арилсан байна |
| 72 | Худалдан авах ажиллагааны тайланг хуулийн хугацаанд tender.gov.mn цахим системд байршуулж, тайлагнах | Тоо: Зохион байгуулсан төсөл арга хэмжээний тоо Чанар: tender.gov.mn цахим системд байршуулж, ил тод байдлыг хангах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | Худалдан авах ажиллагааг ил тод, шуурхай зохион байгуулж, мэдээлсэн байна |
| 73 | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх, хяналт тавих | Тоо: Шинэ төрсөн хүүхэд, Нас барсан хүн, шилжилт хөдөлгөөний тоо Чанар: Мэдээллийн сангийн баяжилт хийгдсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт хийгдэж, мэдээлэл нь бодиттой болсон байна. |
| Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнс, худалдаа үйлчилгээний салбарын хүрээнд: | | | |
| 74 | Сумын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих түвшинд бэлтгэх | Тоо: Аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийн хэмжээгээр Чанар: Зудын эрсдэлээс сэргийлсэн байна. Хугацаа: Бүтэн жилээр тайлагнана. | Сумын өвс, тэжээлийн нөөцийг зохих түвшинд бэлтгэн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 85-аас дээш хувиар хангасан байна. |
| 75 | Малын шилжилт хөдөлгөөн болон малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах | Тоо: Малын бүртгэл мэдээллийн системд бүртгэгдсэн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний тоогоор Чанар: Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж эрсдэлийг бууруулсан байна. |
| 76 | Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, үйл ажиллагаанд хяналт хавих | Тоо: Хоршоодод олгосон зээлийн тоо, зээлийн хэмжээгээр Чанар: Хоршоодыг дэмжиж ажилласан байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | Хоршоодыг чадавхжуулж, хөнгөлөлттэй зээлийн журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. |
| 77 | Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тариалалт ургац хураалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Тоо: Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар Чанар: Тариалах талбайн хэмжээ өмнөх оны дүнгээс өсөж, төмс хүнсний ногооны | Хавсралтаар өгөгдсөн тариалалт ургац хураалтын төлөвлөгөөг бүрэн хангасан байна. |

| | | | |
|--|---|---|---|
| | | хангамж нэмэгдсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | |
| 78 | Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах | Тоо: Урьдчилан сэргийлэх үзлэг тарилгад хамруулсан малын тоо Чанар: Малын халдварт, гоц халдварт өвчин гараагүй байна Хугацаа: Хагас, бүтэн жилээр тайлагнана. | Малын халдварт, гоц халдварт өвчин гараагүй байна. |
| Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд: | | | |
| 79 | “Тэрбум мод” тарих ажлын хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Шинээр тарьж ургуулсан модны тоо, ургалтын хувь Хагас бүтэн жилээр тайлагнах | Шинээр 25.0 мянган мод тарьсан байна ургалт 70-аас дээш хувьтай байна |
| 80 | Булгийн эхийг хашиж хамгаалах тохижуулах ажлыг зохион байгуулах | Тоо: Хамгаалсан булгийн тоо Чанар: Усны нөөцийг хуримтлуулсан байна. Хугацаа: Тайланг тухай бүр ирүүлнэ. | Гол мөрний урсац нэмэгдсэн байна. |
| 81 | Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн бодлого төлөвлөлтийг сайжруулах | Тоо: Стандартын ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн шаардлага хангасан ундны ус ашиглагчдын тоо Чанар: Иргэдийн ундны ус, ариун цэврийн байгууламжийн чанар, хүртээмж сайжирсан байна. Хугацаа: Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хагас бүтэн жилээр тайлагнах | Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна. |
| 82 | Нүхэн жорлонгийн тоог багасгаж, хөрсний бохирдлыг бууруулах | Тоо: Жилд 5-аас доошгүй Чанар: Стандартын шаардлага хангасан эко 00-той болсон. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | Нүхэн жорлонгийн тоог бууруулсан байна |
| 83 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуулийн дагуу зарцуулах, хяналтыг сайжруулах | Тоо: Байгаль хамгаалахад зарцуулсан орлогын хэмжээ, хувь, Чанар: Байгаль орчны доройтол багассан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах нөхцөл бүрдсэн байна |
| 84 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, тогтолцоог нэвтрүүлэх | Тоо: Ангилан ялгаж нийлүүлсэн хогны хэмжээ /тонн/ Чанар: Хог хаягдлын хэмжээ багассан байна Хагас бүтэн жилээр тайлагнах | Иргэдийн цэвэр эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ |
| 85 | Стандартад нийцсэн хогийн савыг байршуулах | Байршуулсан хогийн савны тоо Ил задгай хог хаяхгүй болсон байна | 10-аас доошгүй хогийн сав байршуулсан байна. |

| | | | |
|--|---|--|--|
| | | Хагас бүтэн жилээр тайлагнах | |
| 86 | Бичил уурхайн эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих | Тоо: Хяналт хийсэн тоо Чанар: Зөрчлийн тоо буурсан байна Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | Байгаль орчныг хамгаалсан байна. |
| 87 | Ашигт малтмал, газрын тосны уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хяналт тавих | Чанар: Хайгуул, олборлолтыг хуулийн дагуу хийсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | Байгалийн баялгийг зүй зохистой ашигласан байна |
| Хөрөнгө оруулалтын чиглэлийн хүрээнд: | | | |
| 88 | Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналыг хууль журмын дагуу боловсруулан иргэд, олон нийтийн саналыг авч, эрэмбэлэн холбогдох хэлтэст ирүүлэх | Тоо: Төсөл, арга хэмжээний тоо, санал өгсөн иргэдийн тоо Чанар: Иргэдийн тулгамдсан асуудлыг оновчтой тодорхойлж, саналд тусгана. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнана. | 2023 онд Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон байна. |
| Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд: | | | |
| 89 | Батлан хамгаалах үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангах | Тоо: Сурталчилсан ажлын тоо Биелэлтийн хувь Чанар: Батлан хамгаалах тухай хууль, тогтоомжийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлнэ. Хугацаа: Жилдээ | Орон нутагт батлан хамгаалах үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомжийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд сурталчилснаар иргэдийн цэргийн үүргийн биелэлт дээшилнэ. |
| 90 | Цэргийн бүртгэлийг зохион байгуулан явуулах, мэдээ, судалгаа, тайланг ирүүлэх | Тоо: 1 удаа Чанар: Аймгийн Засаг даргын захирамжаар цэргийн бүртгэлийг хөтлөн явуулна. Хугацаа: 1 дүгээр улиралд | Цэргийн бүртгэл судалгааны нэгдсэн тогтолцооны чанар дээшилсэн байна |
| 91 | Цэрэг татлагын ажлыг зохион байгуулж хяналтын тоог биелүүлэх | Тоо: 1 удаа Чанар: Аймгийн Засаг даргын захирамжаар цэрэг татлагын ажлыг зохион байгуулна. Хугацаа: 2, 4 дүгээр улиралд | Цэрэг татлагын хяналтын тоо биелэгдэнэ. |
| 92 | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг сум, орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулах | Тоо: Алба хааж байгаа иргэдийн тоо Чанар: Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг оролцуулна. Хугацаа: Жилдээ | Орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцох оролцоо сайжирна. |
| 93 | Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр төлөх иргэдийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | Тоо: Мөнгөн төлбөр тогтоосон иргэдийн тоо Чанар: Мөнгөн төлбөрийн болзол хангасан иргэдийг төлбөр төлүүлнэ. Хугацаа: Жилдээ | Мөнгөн төлбөрийн орлого нэмэгдэнэ. |